



ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 02 сарын 19 өдөр

Дугаар А/95

Хэрлэн сум

Гэр бүлийн хөгжлийн цогц үйлчилгээний
төвийг бүсчлэн байгуулахад хөрөнгө
зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 19 дугаар зүйлийн 19.1.1, 19.1.4 дэх заалт, Гэр бүл, Хөдөлмөр, нийгэм хамгааллын салбарын хууль тогтоомж, бусад баримт бичигт заасан эрх хэрэгжүүлж үүрэг гүйцэтгэх 2025 онд байгуулсан гэрээний 3.1.2.2 дахь заалт, Хэнтий аймгийн иргэдийн Төлөөлөгчийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 04 дүгээр тогтоолын 1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.1.1.1 дэх заалтад заагдсан Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын "Ирээдүйн эзэд" хөтөлбөрийн хүрээнд Батноров, Бор-Өндөр сумдад Гэр бүлийн хөгжлийн цогц үйлчилгээний төвийг бүсчлэн байгуулсугай.

2. Гэр бүлийн хөгжлийн цогц үйлчилгээний төвийн ажиллах журмыг 1 дүгээр хавсралтаар, хөрөнгө зарцуулалтын тооцоог 2 дугаар хавсралтаар баталсугай.

3. Төвийн сэтгэл зүйчийн цалин, үйл ажиллагаанд зарцуулагдах 65,000,000 (жаран таван сая) төгрөгийн хөрөнгийг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн зардлаас олгохыг аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Н.Үнэнбат)-д даалгасугай.

4. Гүйцэтгэлийг үр дүнтэй зохион байгуулж, тайлагнахыг Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын дарга (Х.Уртнасан)-д, дэмжлэг үзүүлж ажиллахыг сумын Засаг дарга нарт, хяналт тавьж ажиллахыг аймгийн Нийгмийн бодлогын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Түмэнжаргал)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

ДАЮУРБУНЬ





۴۰/۴۰

۴۵۲ ۲۵ ۵۵
بصر و بصر (بصر) بصر

فہرست مضامین:



**СУМ ДУНДЫН ГЭР БҮЛИЙН ХӨГЖЛИЙН ЦОГЦ
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨВД ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ЖУРАМ**

Нэг: Нийтлэг үндэслэл

1.1 Энэхүү журмын зорилго нь Нийгмийн суурь үндэс болсон гэр бүлийн хөгжлийг дэмжихэд чиглэсэн, тулгамдсан асуудлыг цогцоор шийдвэрлэх шуурхай тусламж үзүүлэх, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хамгаалах, нөхөн сэргээх нийгмийн ажлын үйлчилгээг гишүүн бүрд хүргэх, гэр бүлд суурилсан нийгмийн үйлчилгээг сумын иргэдийн эрэлт, хэрэгцээнд нийцүүлэн цогц үйлчилгээ үзүүлэхэд оршино.

1.2 Энэхүү журмаар сумын гэр бүлийн хөгжлийг дэмжих, гэр бүлийн аюулгүй байдлыг хангах, хосын харилцааг сайжруулах, урьдчилан сэргийлэх, гэр бүлийн тогтвортой байдлыг дэмжих, эрсдэлт, зорилтод гэр бүлд чиглэсэн шуурхай тусламж, хамгаалах, нөхөн сэргээх зэрэг үйлчилгээг Сум дундын Гэр бүлийн хөгжлийн цогц үйлчилгээний төвөөр дамжуулан үзүүлэх харилцааг зохицуулна.

1.3 Энэхүү журмыг хэрэгжүүлэхэд Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, Гэр бүлийн тухай хууль, тэдгээртэй нийцэж гарсан эрх зүйн акт, бусад холбогдох хууль тогтоомж, Гэр бүлд үзүүлэх нийгмийн ажлын үйлчилгээнд тавих нийтлэг шаардлагыг удирдлага болгоно.

Хоёр: Нэр томъёоны тодорхойлолт

2.1 “Гэр бүлийн хөгжлийн төв”- Гэр бүлийн гишүүдийн эрэлт, хэрэгцээ, тулгамдаж буй асуудал, саад бэрхшээлийг даван туулахад чиглэсэн зөвлөн туслах, үйлчилгээ үзүүлэх эрх бүхий байгууллагыг.

2.2 “Гэр бүлийн хөгжлийн цогц үйлчилгээ”- Гэр бүлд чиглэсэн гэр бүлийн аюулгүй байдлыг хангах, хосын харилцааг сайжруулах, тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хамгаалах, дэмжих үйлчилгээг нэг дороос үзүүлэх.

2.3 “Гэр бүлийн хөгжлийн цогц үйлчилгээний төвийн ажилтан”- Стандарт шаардлагад нийцсэн зохих мэргэжлийн боловсролтой гэр бүлийн өмнө тулгарч буй асуудлыг онолын түвшинд судлах, шийдвэрлэх арга зам боловсруулах, шалгагдаж баталгаажсан оношилгооны аргуудыг хэрэглэж зөвлөх үйлчилгээ үзүүлэх ур чадвар бүхий боловсон хүчин.

2.4 “Гэр бүлийг дэмжих үйлчилгээ”- Гэр бүлийн амьдралд сөрөг асуудал үүсэхээс урьдчилан сэргийлэх, гэр бүлийн тогтвортой байдлыг дэмжих, нийгмийн үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх зорилгоор зохион байгуулж буй гэр бүлийн боловсрол олгох сургалт, үйлчилгээний ажлыг

2.5 “Гэр бүлийн боловсрол олгох”- Гэр бүлийн тогтвортой, зөв харилцаатай, хүний амар тайван аж төрж, хөгжих боловсрох суурь орчин болгон хөгжүүлэхэд шаардлагатай мэдлэг чадварын цогцыг

2.6 “Гэр бүлийг хамгаалах үйлчилгээ”- Гэр бүлийн харилцаа холбоог бэхжүүлэх, гэр бүлийн хямрал, зөрчлийг намжаан харилцааг тогтворжуулах, эрсдэлээс гэр бүлийн гишүүдийг хамгаалах зорилгоор хувь хүн болон гэр бүлд зөвлөн туслах үйлчилгээг

2.7 “Гэр бүлийн зөвлөгөө”- Гэр бүлийн өмнө тулгамдаж байгаа бэрхшээлийг даван туулахад чиглэгдсэн үйлчлүүлэгч ба ажилтны хооронд хамтын идэвхтэй үйл ажиллагаа бөгөөд үйлчлүүлэгч өөрт тохиолдсон асуудлаа бодитойгоор ойлгох, шийдвэрлэхэд туслах нөлөөллийн өвөрмөц арга техник

2.8 “Үйлчлүүлэгч”- Өөрт тулгамдсан асуудлаар мэргэжлийн зөвлөгөө, тусалцаа авахаар гэр бүлийн зөвлөгөө өгөх төвд хандсан хувь хүн, гэр бүлийн гишүүдийг

2.9 “Эрсдэлт нөхцөлд байгаа гэр бүл”- Гэр бүлийн болон хүүхдийн эсрэг хүчирхийлэл, гамшиг, онцгой, аюултай нөхцөлд байгаа гэр бүлийг

2.10 “Зорилтод бүлгийн гэр бүл” - Харилцааны хямрал, зөрчлөө даван туулж гэр бүлийн таатай уур амьсгалыг бүрдүүлэх эрмэлзэлтэй, Хүүхэдтэйгээ харилцах харилцааны үл ойлголцолтой, Сэтгэл зүйн зөвлөгөөнд хамрагдах өөрийн хүсэлтэй, Архи согтууруулах ундааны хамаарлын 1-р үед байгаа хүн, Ажил хөдөлмөр эрхлэх сонирхолгүй, Нийттэй харилцах харилцааны зөрчилтэй, Уй гашуу тохиолдсон, Гэр бүл, хосын харилцаагаа сайжруулах хүсэлтэй өрх гэр бүлийг

2.11 “Шуурхай тусламжийн үйлчилгээ”-Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг хүчирхийлэл, гамшиг, онцгой, аюултай нөхцөл байдалд өртсөн, өртөх эрсдэлтэй гэр бүл, гэр бүлийн гишүүдийг хамгаалах, аюулгүй байдлыг хангах, шуурхай тусламжийн үйлчилгээг үзүүлэх

2.12 “Хамгаалах-нөхөн сэргээх үйлчилгээ”- Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг хүчирхийлэл, гамшиг, онцгой, аюултай нөхцөл байдалд өртсөн, өртөх эрсдэлтэй гэр бүл, гэр бүлийн гишүүдийг шаардлагатай нийгмийн үйлчилгээнд холбон зуучлах, хямралаас гарах, хэвийн амьдралдаа орох асуудал бэрхшээлийг даван туулахад нь гэр бүлийн орчинд эсхүл гэр бүлийн орчноос тусад нь хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээ

Гурав: Удирдлага зохион байгуулалт

3.1 Сум дундын Гэр бүлийн хөгжлийн цогц үйлчилгээний төв нь Хэнтий аймгийн Хүүхэд гэр бүлийн хөгжил хамгааллын газрын харьяанд үйл ажиллагаагаа явуулна.

3.2 Сум дундын Гэр бүлийн хөгжлийн цогц үйлчилгээний төв нь Хэнтий аймгийн сумдад бүсчилсэн хэлбэрээр ажиллах бөгөөд сумдыг хойд бүс, урд бүс, зүүн бүс, баруун бүс гэж хуваасан байна.

3.3 Сум дундын Гэр бүлийн хөгжлийн цогц үйлчилгээний төв нь холбогдох хуулиар үүрэг хүлээсэн байгууллага, алба хаагч, мэргэжилтэнтэй хамтран ажиллаж, хариуцсан бүсийн иргэд, гэр бүлүүдэд цогц үйлчилгээг шуурхай, хүртээмжтэй хүргэнэ.

3.4 Сум дундын Гэр бүлийн хөгжлийн цогц үйлчилгээний төвд нийгмийн ажилтан, сэтгэл зүйч гэсэн орон тоогоор ажиллана.

3.5 Нийгмийн ажилтан, сэтгэл зүйч нь Сум дундын Гэр бүлийн хөгжлийн цогц үйлчилгээний төвөөр дамжуулан бүсийн иргэд, зорилтод бүлгийн гэр бүл, өрхүүдэд Гэр бүлд чиглэсэн урьдчилан сэргийлэх үйлчилгээ, шуурхай тусламжийн үйлчилгээ, эрсдэлт нөхцөлд байгаа гэр бүлийг хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлнэ.

3.6 Сум дундын Гэр бүлийн хөгжлийн цогц үйлчилгээний төв нь гэр бүлийн болон бусад төрлийн хүчирхийллийн хохирогч болон эрсдэл бүхий өрх, зорилтод бүлгийн гэр бүлд богино хугацаанд шаардлагатай үйлчилгээг үзүүлж, дунд болон урт хугацааны нөхөн сэргээх үйлчилгээнд холбон зуучилна.

3.7 Салбар дундын хамтын ажиллагаа хөгжүүлэх, бусад салбарын байгууллагын мэргэжилтнүүдтэй хамтран ажиллах.

3.8 Гэр бүлд чиглэсэн урьдчилан сэргийлэх үйлчилгээг иргэд, байгууллага олон нийтэд шууд үзүүлэхээс гадна E-FAMILY цахим платформыг ашиглаж, зохион байгуулах, зарим үйлчилгээг магадлан итгэмжилсэн ТББ-аар гэрээлэн гүйцэтгүүлнэ.

3.9 Шуурхай тусламжийн үйлчилгээг орон нутгийнхаа нөөц боломж, чадамжид тулгуурлаж үзүүлнэ.

3.10 Эрсдэлтэй гэр бүлд чиглэсэн хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээний орон нутгийн чадамж, нөөц боломжид тулгуурлан гүйцэтгэх, зарим үйлчилгээг магадлан итгэмжилсэн ТББ-аар гэрээлэн гүйцэтгүүлнэ.

Дөрөв: Үйлчилгээний төрөл

4.1 Сум дундын Гэр бүлийн хөгжлийн цогц үйлчилгээний төв нь

4.1.1 Гэр бүлд чиглэсэн урьдчилан сэргийлэх үйлчилгээ—Гэр бүл, түүний гишүүдийг эрсдэлээс хамгаалах, тулгарч буй асуудалд дахин өртөхөөс урьчилан сэргийлэх, гэр бүлийн амьдарлаа эрүүл, бүтэн, хэвийн авч явахад туслах хөгжүүлэх

мэдлэг чадварыг дээшлүүлэхэд чиглэсэн олон талт хамтарсан болон зорилтод бүлэгт чиглэсэн нөлөөллийн арга хэмжээ авна. Гэр бүлд чиглэсэн урьдчилан сэргийлэх үйлчилгээ нь зорилтод гэр бүл, хүүхэд, залуучуудыг амьдралд бэлтгэх болон гэр бүлийн мөчлөгийн онцлог асуудлыг даван туулах сургалт, сурталчилгаа, нөлөөллийн ажлууд байна.

А. Хүүхэд залуучуудыг амьдралд бэлтгэх, урьдчилан сэргийлэх үйлчилгээгээр

- Үерхэл нөхөрлөл, хил хязгаарын тухай ойлголт,
- Бэлгийн боловсрол,
- Гэр бүлийн эрүүл, эрүүл бус харилцааны тухай,
- Өөрийгөө таньж олох, бүтээх,
- Амьдралын стратеги, ирээдүйн талаар эрүүл төсөөлөл,
- Гэрлэлт, гэрлэлтийн талаарх ойлголт мэдлэгийг олгоно.

Б. Гэр бүлд чиглэсэн урьдчилан үйлчилгээгээр

- Гэр бүлийн боловсрол олгох сургалт, сурталчилгаа, үйлчилгээ
- Зорилтод бүлгийн гэр бүлд чиглэсэн сургалт, үйлчилгээ,
- Угийн бичиг хөтлөх арга зүйг түгээн дэлгэрүүлэх үйл ажиллагаа
- Гэр бүлийн гишүүдэд ажил мэргэжлийн чиг баримжаа олгох сургалт,

зөвлөгөө

- Байгууллагын эцэг эхийн зөвлөлийн үйл ажиллагааг дэмжих, арга зүй олгох
- Гэр бүл, сургууль, олон нийтийн хамтын ажиллагааг бэхжүүлэх өдөрлөг

явуулах

• Эрсдэлт зан үйл, хорт зуршлаас сэргийлэх сургалт, сурталчилгаа, үйл ажиллагаа

• Эцэг, эх асран хамгаалагчдыг хүүхдээ асрах, хамгаалахад шаардлагатай мэдлэгийг олгох, үүрэг хариуцлагыг ойлгуулах арга хэмжээ

• Залуу гэр бүл болон нийт гэр бүлийг дэмжих хөгжлийн олон талт үйлчилгээ

В. Хүн амын бүлгүүдийн амралт, чөлөөт цаг, боловсролыг дэмжих олон нийтэд чиглэсэн хөгжлийн үйлчилгээгээр.

- Өсвөр залуу үеийнхэн зориулсан төрөл бүрийн секц дугуйлан
- Залуу ээжүүдийн клуб
- Аав нарын дэмжих бүлэг
- Хуримын ёслол, ургийн баяр
- Ахмадын амралт чөлөөт цагт зориулсан хөгжлийн үйлчилгээ
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан хөгжлийн үйлчилгээ

4.1.2 Гэр бүлд чиглэсэн шуурхай тусламжийн үйлчилгээ – Гэр бүлийн болон хүүхдийн эсрэг хүчирхийлэл, гамшиг, онцгой, аюултай нөхцөл байдалд байгаа болон өртөх эрсдэлтэй гэр бүл, гэр бүлийн гишүүдийг хамгаалах, аюулгүй байдлыг хангах, шуурхай тусламжийн үйлчилгээг үзүүлэх арга хэмжээ авна.

- Хямралын үеийн зөвлөгөө, тусламж (сэтгэл зүйн болон хуулийн анхан шатны зөвлөгөө, эд материалын тусламж)

- Шуурхай тусламжийн үйлчилгээ (Түр хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээ, хоргодох байр, сэтгэл зүй, эрүүл мэнд, эрх зүй, хоол хүнс, дулаан хувцсаар хангах зэрэг анхан шатны тусламж үйлчилгээнд холбон зуучлах)

- Орон нутгийн онцгой комисстой хамтран, шаардлагатай арга хэмжээг шуурхай авах

- Хамтарсан багийн үйлчилгээ
- Эмнэлгийн яаралтай тусламж үйлчилгээнд холбон зуучлах
- Бусад холбогдох байгууллагад холбон зуучлах үйлчилгээ

4.1.3 Эрсдэлт нөхцөлд байгаа гэр бүлд чиглэсэн хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээ- Эрсдэлт нөхцөлд байгаа гэр бүлийн гишүүдийн зан үйлд нөлөөлөх, бие даан амьдрах ур чадвар, мэргэжил мэдлэгийг дээшлүүлэх сургалт, зөвлөгөөнд хамруулж, гэр бүлийг дэмжих шаардлагатай үйлчилгээнд холбон зуучилна.

А. Сэтгэл зүйн зөвлөгөө, засал болон хууль эрх зүйн зөвлөгөө шууд өгөх үйлчилгээ.

- Хувь хүнд чиглэсэн: Ганцаарчилсан, утсаар зөвлөгөө,
- Гэр бүлд чиглэсэн: Хосын зөвлөгөө, дараалуулан зөвлөгөө өгөх, бүлгийн зөвлөгөө.

- Олон нийтэд чиглэсэн: Цахим зөвлөгөө,

Б. Гэр бүлийг дэмжих нийгмийн үйлчилгээнд холбон зуучлах

- Газар өмчлөх, орон сууцтай холбоотой үйлчилгээ
- Бие даан амьдрахад туслах үйлчилгээ
- Шилжилт хөдөлгөөнд холбогдох үйлчилгээ
- Цэцэрлэг, сургууль, зусланд хамруулах үйлчилгээ
- Эрүүл мэндэд чиглэсэн үйлчилгээ

В. Гэр бүлийн эдийн засаг амьжиргааг дэмжих холбон зуучлах үйлчилгээ

- Хүнсний талон, халамжийн тэтгэмж авах, асрамжийн үйлчилгээ
- Олон нийтийн оролцоонд суурилсан хөгжлийн үйлчилгээ
- Ажлын байртай болоход дэмжлэг үзүүлэх

- Хөдөлмөрт бэлтгэх, мэргэжилтэй болгох үйлчилгээнд холбон зуучлах
- Хувиараа хөдөлмөр эрхлэх, бизнес эрхлэхэд нь дэмжлэг үзүүлэх
- Г. Гэрлэлт цуцлалт ба үрчлэлтэй холбоотой цогц үйлчилгээ
- Эвлэрүүлэн зуучлах үйлчилгээ
- Гэр бүлийн шинжээч
- Гэрлэлт цуцлалтын дараах тэжээн тэтгэх үүргийг хэрэгжилт, түүнд хяналт

тавих хариуцлага тооцох

- Хүүхдийн эрх хамгааллын нөхцөл байдалд хяналт тавих, үнэлгээ
- Д. Хөгжлийн бэрхшээлтэй иргэнтэй өрхийг дэмжих үйлчилгээ
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ
- Эрүүл мэнд ба эрх зүйн туслалцаа
- Нөхөн сэргээх өдрийн үйлчилгээ
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэн, түүний асран хамгаалагчдад сэтгэл зүйн

ганцаарчилсан ба бүлгийн зөвлөгөө

- Байнгын асаргаатай хүүхдийг зуслангийн хөгжлийн хөтөлбөрт хамруулах үйлчилгээ

Е. Хорт зуршлын хамааралтай гишүүнтэй гэр бүлд үзүүлэх үйлчилгээ

- Холбогдох мэргэжлийн байгууллагад холбон зуучлах үйлчилгээ

Тав: Сум дундын Гэр бүлийн хөгжлийн цогц үйлчилгээний төвийн ажилтнуудын эрх үүрэг

5.1 Сум дундын Гэр бүлийн хөгжлийн цогц үйлчилгээний төвийн нийгмийн ажилтан нь Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 26 дугаар зүйл, Гэр бүлд зөвлөгөө өгөх төвд тавих нийтлэг шаардлагаас гадна дор дурдсан үүрэгтэй.

5.1.1 үйлчлүүлэгчийг хүлээн авч бүртгэх, үйлчилгээ төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэх, дуусгавар болох хүртэлх бүх үе шатны үйл ажиллагааг зохион байгуулах

5.1.2 үйлчлүүлэгчийн хэрэгцээ, нөхцөл байдлыг харгалзан шаардлагатай үйлчилгээнд холбон зуучлах

5.1.3 Хөгжлийн бэрхшээлтэй үйлчлүүлэгч, иргэн, өндөр настанд тусгайлан туслалцаа үзүүлэх

5.1.4 Шаардлагатай тохиолдолд үйлчлүүлэгчийг нэг цэг үйлчилгээний төв, түр хамгаалах байранд шилжүүлэх арга хэмжээ

5.1.5 Үйлчлүүлэгчийн хувийн хэргийн хөтлөх, үйлчилгээний явц, үр дүнгийн талаар тухай бүр илтгэх хуудсаар дээд албан тушаалтанд өгөх, мэдэгдэх, үйлчлүүлэгчийн холбогдох мэдээллийг нэгтгэн мэдээллийн санд оруулах, үйлчилгээний нэгдсэн тайлан мэдээ гаргах

5.2 Сум дундын Гэр бүлийн хөгжлийн цогц үйлчилгээний төвийн сэтгэл зүйч нь Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 38 дугаар зүйлд заасан сэтгэл зүйн үйлчилгээг зохих журмын дагуу үзүүлэхээс гадна дор дурдсан үүрэгтэй.

5.2.1 Үйлчлүүлэгч, хохирогчийг хүлээн авах, үйлчилгээ үзүүлэх, бүхий л үе шатанд сэтгэл зүйн тусламж, үйлчилгээ үзүүлэх

5.2.2 Сэтгэл зүйн үйлчилгээний журмын дагуу үйлчлүүлэгчид сэтгэл зүйн зөвлөгөө өгөх

5.2.3 Сэтгэл зүйн үйлчилгээ авахаар хандсан болон зорилтод бүлгийн гэр бүлд үйлчилгээ үзүүлэх, үйлчилгээний төлөвлөлт гаргаж дээд албан тушаалтад танилцуулах, сэтгэл зүйн байдлын талаар дүгнэлт гаргах, бусад мэргэжилтэн албан хаагчидтай хамтран ажиллах

5.2.4 Үйлчлүүлэгчийн сэтгэл зүйн байдлыг судлан тогтоож, шаардлагатай тохиолдолд нарийн мэргэжлийн сэтгэл заслын эмчилгээнд холбон зуучилж, эргэх холбоотой ажиллах

5.2.5 Үйлчлүүлэгч, хүчирхийллийн хохирогчид үйлчилгээ үзүүлсэн сэтгэл зүйн үйлчилгээний тэмдэглэл хөтлөх, үйлчилгээний явц, үр дүнгийн талаарх холбогдох мэдээллийг нэгтгэн мэдээллийн санд оруулах, үйлчилгээний нэгдсэн тайлан гаргах

Зургаа: Сум дундын Гэр бүлийн хөгжлийн цогц үйлчилгээний төвөөр үйлчлүүлж буй үйлчлүүлэгчийн эрх үүрэг

6.1 Үйлчлүүлэгч нь Сум дундын Гэр бүлийн хөгжлийн цогц үйлчилгээний төвөөр үйлчлүүлэхдээ дараах эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

6.1.1 Анхан шатны болон яаралтай тусламжийн, үйлчилгээ авах эрхтэй.

6.1.2 Хувийн нууцаа хамгааллуулах, тухайн асуудлаар шаардлага тавих эрхтэй.

6.1.3 Сум дундын Гэр бүлийн хөгжлийн цогц үйлчилгээний төвийн үйлчилгээний санал, гомдол гаргах эрхтэй.

6.1.4 Өөрийн болон үйлчлүүлж байх хугацаандаа олж мэдсэн бусад хүний нууцыг хангаж, нууцлах үүрэгтэй.

6.1.5 Үйлчлүүлэгч нь Сум дундын Гэр бүлийн хөгжлийн цогц үйлчилгээний төвийн дотоод журмыг мөрдөж, ажилтнуудад хүндэтгэлтэй хандах, ажилтны тавьсан хууль ёсны шаардлагыг биелүүлэх үүрэгтэй.

Долоо: Гэр бүлийн хөгжлийн цогц үйлчилгээний төвийн сумын Засаг даргын чиг үүрэг

7.1 Сум дундын Гэр бүлийн хөгжлийн цогц үйлчилгээний төвийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, төвийн үйл ажиллагаа явуулах байраар хангах,

цаашид төвийн үйл ажиллагааны зардлыг Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.1-д заасныг баримтлан орон нутгийн төсөвт тусгах,

7.2 Хохирогч, үйлчлүүлэгчид үйлчилгээ үзүүлэх, Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх ажилд иргэд олон нийтийг татан оролцуулах ажлыг харьяалах нутаг дэвсгэртээ зохион байгуулах, Гэр бүлийн хөгжлийн цогц үйлчилгээний төвтэй хамтран ажиллах,

7.3 Нийгмийн ажилтан, сэтгэл зүйчийг гэр бүлийн хүчирхийллийн хохирогч, үйлчлүүлэгчтэй ажиллахад шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах, тогтвортой ажиллах нөхцөлийг бүрдүүлэх үүрэгтэй.

Найм: Тайлагнах, хяналт шинжилгээ, үнэлгээ

8.1 Сум дундын Гэр бүлийн хөгжлийн цогц үйлчилгээний төв нь үйл ажиллагааны тайлан, холбогдох тоо мэдээг хагас бүтэн жилээр гаргаж, аймгийн Гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан мэргэжилтэнд хүргүүлнэ.

8.2 Сум дундын Гэр бүлийн хөгжлийн цогц үйлчилгээний төвийн үйл ажиллагаанд аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын газар тогтмол хяналт тавьж ажиллана.

8.3 Сум дундын Гэр бүлийн хөгжлийн цогц үйлчилгээний төвийн үйл ажиллагаанд жилд 1 удаа аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын газраас хяналт, шинжилгээ, үнэлгээ хийнэ.

Ес: Хариуцлага

9.1 Сум дундын Гэр бүлийн хөгжлийн цогц үйлчилгээний төвийн ажилтнуудын үйл ажиллагаанд саад учруулсан, ажилтны тавьсан хууль ёсны шаардлагыг биелүүлээгүй этгээдэд Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1-д заасан хариуцлага хүлээлгэнэ.

9.2 Хохирогч, үйлчлүүлэгчийн амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдал, хувийн нууц, нэр төрд халдсан мэдээ мэдээллийг тараасан, түгээсэн, задруулсан үйлчлүүлэгч, иргэн, төвийн ажилтанд Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1, 46.2-т заасан хариуцна хүлээлгэнэ.

